



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 08 өдөр

Дугаар А/34

Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрүүл чийрэг Норовлинчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд Норовлин суманд зохион байгуулагдах олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний шагналд 2216000 (хоёр сая хоёр зуун арван зургаан мянга) төгрөг, аймгийн аварга шалгаруулах нийтийн цэнгээнт бүжгийн тэмцээний шагналд 2100000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 4316000 (дөрвөн сая гурван зуун арван зургаан мянга) төгрөгийн зардлыг мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ